“БЗӨБЦТС” ТӨХК-ИАС 2025 ОНЫ 4 ДҮГЭЭР УЛИРАЛД
ЗОХИОН БАЙГУУЛСАН ОЛОН НИЙТИЙН АЖЛЫН ТАЙЛАН

Тэрбум мод тарих үндэсний хөдөлгөөн

Экологийн тэнцвэрт байдлыг хадгалах, ногоон хөгжлийг дэмжих зорилготой “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд энэ 10 дугаар сарын эхний 7 хоногийн баасан гарагт Хэнтий ЦТСС-ын эзэмшлийн Баянмөнхийн цэцэрлэгт хүрээлэнд байрлах Эрчим төгөлд нийт 110 ш улиас мод, Говьсүмбэр ЦТСС-ын Сүмбэр гарден-2 цэцэрлэгт хүрээлэнд 800 ширхэг мод тус тус тарьсан.

Бүх нийтийн цэвэрлэгээнд нэгдлээ

Улаанбаатар хот болон орон нутагт 2025 оны 4 улиралд зохион байгуулагдсан бүх нийтийн цэвэрлэгээнд төв компани, 5 салбарын нийт ажилтнууд хамрагдаж байгууллага тус бүрийн эзэмшлийн 50 м хүртэлх нийтийн эзэмшлийн зам талбайг мөн хуваарьт газрыг цэвэрлэж, үүсмэл хогийн цэгүүдийг ачиж зайлуулав.

Хөдөлгөөн эрүүл мэнд

Ажлын байрны дасгал хөдөлгөөнийг Дорноговь ЦТСС-ын ажилтнууд өдр бүр 5-10 минутын өглөөний дасгал хийж хэвшсэн.

Монгол улсад авто тээврийн салбар үүсч хөгжсөний 100 жилийн ойн спортын наадамд Тээвэр үйлчилгээний хэсэгхэн оролцож багийн нийлбэр дүнгээр 3-р байр эзэлсэн

Ажилчдын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, хамт олонч уур амьсгалыг нэмэгдүүлэх зорилгоор Хэнтий аймгийн Засаг даргын тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн харьяа байгууллагуудын хооронд 4 төрөлт спортын наадамд амжилттай оролцож, 9 багийн 80 гаруй тамирчидтай өрсөлдөн багийн нийлбэр дүнгээр 2-р байр эзэлсэн. Уламжлал болгон зохион байгуулдаг “БЗӨБЦТС” ТӨХК-ий аварга шалгаруулах спортын таван төрлийн XXI их наадмыг орон нутагтаа амжилттай зохион байгуулж багийн дүнгээр 2-р байранд шалгарсан.

Хэнтий аймгийн ахмадын холбоотой хамтран Хэнтий аймгийн ахмадын баярын үйл ажиллагааг зохион байгуулж, байгууллагын үйл ажиллагааг танилцуулсан. Уг үйл ажиллагаанд 180 гаруй ахмадууд хамрагдсан.

<u>Сургалт, хөгжүүлэлтийн чиглэлээр</u>

Компаний 2025 оны 12 сарын 01-ний өдөр ирүүлсэн 06/1174 дугаар албан бичгийн дагуу “ТЕХНОЛОГИ АШИГЛАН ҮЙЛДЭГДЭЖ БУЙ ЖЕНДЕРТ СУУРИЛСАН ХҮЧИРХИЙЛЭЛТЭЙ ТЭМЦЬЕ” аяны хүрээнд 2025 оны 12 сарын 05-12 сарын 10-ны өдрүүдэд төлөвлөгөө гаргаж, сургалт нөлөөллийн үйл ажиллагааг залуучуудыг зөвлөл амжилттай зохион байгуулласан.

2025 оны 10 сарын 06 өдөр Дундговь ЦТСС-н хамт олон “Хөдөлмөрийн харилцаа” -ны сургалтыг Дундговь аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газартай хамтран амжилттай зохион байгуулласан. Сургалтыг Дундговь аймгийн Хөдөлмөр, халамжийн

үйлчилгээний газрын хөдөлмөр эрхлэлтийн хэлтсийн дарга Э.Цэвэлмаа болон Хөдөлмөр, эрх зүйн харилцааны зөвлөх Г.Нямаа нар чиглүүлэн ажилтан, албан хаагчдад сургалт, зөвлөгөө хүргэлээ.



“Чойр эвэнт” Хариуцлагатай гэр бүл арга хэмжээний хүрээнд сургагч багш урьж “Хариуцлагатай гэр бүл” сэдвээр, Говьсүмбэр аймгийн ГБХЗХГазартай хамтран гэр бүлийн тухай хуулийн мэдлэг олгох сургалтыг тус тус зохион байгууллаа.



<u>Нийгмийн хариуцлагын хүрээнд</u>

Нийгмийн хариуцлагын хүрээнд шинэ жилийн баяраар хамт олноос цугларсан 55 бэлгийг Баганаар дүүргийн 4,5 дугаар хорооны 55 хүүхдэд өгөх ажлыг зохион байгуулж ажиллалаа.